



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/2017

Мандалговь


Г Газар чөлөөлөх тухай 7

Монгол Улсын Газрын тухай хуулийн 57 дугаар зүйл, мөн хуулийн 59 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Монгол Улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4 дэх заалт "Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно"-ыг зөрчиж Сайнцагаан сумын нутаг дэвсгэрт зохих зөвшөөрөлгүй дур мэдэн газар эзэмшиж, ашиглаж, хашаа, гараж барьсан контейнер, амбаар байрлуулсан иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрыг чөлөөлөх ажлыг зохион байгуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) аймгийн Цагдаагийн газар (О.Амарсанаа)-т тус тус үүрэг болгосугай.

Хоёр. Газар чөлөөлөхтэй холбогдон гарах зардлыг Газрын тухай хуулийн 57.4 дэх заалтын дагуу зохих зөвшөөрөлгүй газар эзэмшиж, ашигласан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргуулсугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



430190603